



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.11.01 № 1-1/5327  
танай 2018.10.01 -ны № 41 -Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН Т.АЮУРСАЙХАН ТАНАА**

Таны 2018 оны 10 дугаар сарын 01-ний  
өдрийн 41 тоот асуулгын хариуг хүргүүлж байна.


Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: ... хуудастай.



Ц.НЯМДОРЖ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11...  
дугаар сарын 21-ны өдрийн 1-1/5327 тоот албан  
бичгийн хавсралт



## АСУУЛГЫН ХАРИУ

“Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх,  
урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай”

**НЭГ:** Хүн худалдаалах, хулгайлах гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр барьж буй бодлогын талаар:

Монгол Улсын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/22 тоот тогтоолоор баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци”-ийн нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-д нэгдэн орсныг Улсын Их Хурал соёрхон баталсан бөгөөд “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль”-ийг 2012 онд баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “...мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ...” гэж заасны дагуу Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлуулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд байгуулан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3.3.1-т “...хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий бие даасан бүтцийг байгуулах...” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалахтай тэмцэх хэлтэс болгон өөрчилж, тус хэлтэст Хүн худалдаалахтай тэмцэх тасгийг 1 дарга, 2 ахлах мөрдөгч, 2 мөрдөгчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн 5.8.1-д Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах; 5.8.2-т Итгэмжлэлийн үндсэн дээр гадаад улсад зорчиж байгаа хүүхэд тухайн улсад удаан хугацаагаар сурах, амьдрах тохиолдолд хүлээн авах этгээдийн талаарх мэдээллийг нягтлах; 5.8.3-т Улсын хилээр хамт гарсан насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх гэж заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих” журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүйгээр гадаадад зорчихыг завдсан хилийн боомтуудаас буцаагдсан болон хилийн чанадад үлдсэн хүүхдийн судалгааг сар бүр гарган Цагдаагийн ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн газарт хүргүүлж байна.

#### **ХОЁР: Гэмт хэргийн нөхцөл байдал**

1. Сураггүй алга болсон, эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж буй тохиолдол, нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах санд 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 0-18 насны 1376 хүүхдийг алга болсон төлөвт бүртгэж, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулснаас 1353 хүүхдийг олж, 23 хүүхэд одоогийн байдлаар олдоогүй, эрэн сурвалжлагдаж байна.

Эдгээр олдоогүй байгаа 23 хүүхдийн алга болсон нөхцөл байдлыг авч үзвэл гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй 5, төөрч осолдсон байж болзошгүй 4, үер ус, байгалийн гамшигт осолд өртсөн байж болзошгүй 11, гадуур тэнэдэг байсан 3 гэж тогтоогдсон.

2. Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллагад 2018 оны эхний 9 сарын байдлаар “Хүн худалдаалах” гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 буюу 30 хувиар буурсан мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд шинээр нэмэгдсэн “Бэлгийн мөлжлөг” гэмт хэрэг 2018 он гарсаар 4 бүртгэгдсэн байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн тоо<sup>1</sup>

Он	Хүн худалдаалах / ЭХ-ийн 13.1-р зүйл, 2002 оны ЭХ-ийн 113-р зүйл /			Бэлгийн мөлжлөг / ЭХ-ийн 12.3-р зүйл /		
	Хэрэг	Холбогдогч	Хохирогч	Хэрэг	Холбогдогч	Хохирогч
2013	10	15	61			
2014	8	12	23			
2015	10	13	26			
2016	4	9	28			
2017	10	26	46			
2018	7	16	12	4	4	8

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчдын мэдээлэл /2018 оны эхний 9 сарын байдлаар/<sup>2</sup>

№	Хохирогчийн мэдээлэл	Хүйс		Нас		Боловсрол				Нийгмийн байдал	
		Эр	Эм	14-17	18-аас дээш	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Дээд	Сурагч	Ажилгүй
1	ЭХ-ийн 12.3-р зүйл /Бэлгийн мөлжлөг/	-	4	3	1	1	2	1	-	3	1
2	ЭХ-ийн 13.1-р зүйл /Хүн худалдаалах/	-	12	6	6	1	4	6	1	4	8

Шүүхээр шийдвэрлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн тоо<sup>3</sup>

Хүн худалдаалах хэрэг <sup>4</sup>	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Шийдвэрлэсэн бүгд хэрэг	1	1	2	0	0
Ял шийтгүүлсэн бүгд хүн	1	1	5	2	0

### 3. Хүн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллагад энэ оны эхний 9 сарын байдлаар хүн хулгайлах гэмт хэргийн шинжтэй 21 гомдол бүртгэгдсэнээс, 7 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, 1 хэргийг шүүхэд шилжүүлж, гэмт хэргийн шинжгүй 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 5 хэрэгт шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Цагдаагийн байгууллагаас өгсөн мэдээнд 2013-2017 онд хүн хулгайлах гэмт хэрэг 12 бүртгэгдсэнээс шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

<sup>1</sup> Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

<sup>2</sup> Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

<sup>3</sup> Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

**Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн хулгайлах гэмт хэргийн тоо<sup>4</sup>**

Он	Хэргийн тоо	Хэрэгсэхгүй болсон	Шүүхэд шилжүүлсэн	Ажиллагаанд
2012	1	1	-	-
2013	1	1	-	-
2014	-	-	-	-
2015	-	-	-	-
2016	1	1	-	-
2017	2	-	-	2
2018	7	1	1	5

**Хүн хулгайлах гэмт хэрэг үйлдсэн зорилго, шийдвэрлэлт /2018 оны эхний 9 сарын байдлаар/<sup>5</sup>**

Хохирогч		Гэмт хэрэг үйлдсэн зорилго	Шийдвэрлэлт
нас	хүйс		
5 хоногтой	эм	Хүүхдээ болгох зорилгоор хулгайлсан	Шүүхэд шилжүүлсэн
50 настай	эр	Тодорхойгүй	Мөрдөн байцаалтын шатанд
5 настай	эм	Хүүхдээ болгох зорилгоор хулгайлсан	Мөрдөн байцаалтын шатанд
5-6 настай	эр	Гэмт хэрэг үйлдэгдсэн болох нь тогтоогдохгүй байгаа	Мөрдөн байцаалтын шатанд
42	эм	Хулгайлагдаагүй, 7 хоног гадуур явж байгаад ирсэн	Хэрэгсэхгүй болсон
18 настай	эм	Гадуур тэнэдэг, биеэ үнэлэгч	Мөрдөн байцаалтын шатанд
2.8 настай	эрэгтэй	Эцэг, эхийн танил нь авч явсан.	Мөрдөн байцаалтын шатанд

**ГУРАВ: Хууль, эрх зүйн орчны талаар**

Хүн худалдаалах гэмт хэргийг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т системчилж, Палермогийн протоколын 3 дугаар зүйлд заасан агуулгаар 13.1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан бөгөөд тус протоколын 3 дугаар зүйлд заасан тайлбарууд буюу хүүхдийг худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоох болон хохирогч зөвшөөрсөн эсэх нь хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлд үл нөлөөлөх агуулга нь 13.1 дүгээр зүйлийн тайлбарт бүрэн утгаараа тусгагдсан.

2002 оны Эрүүгийн хуулиар хүн хулгайлах, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн бол гурваас таван жил хүртэл хугацаагаар, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар, эдгээр хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд өөрчлөн биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор

<sup>4,5</sup> Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар

хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтандаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар, хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр хариуцлагыг чангаруулж тогтоосон нь Эрүүгийн хууль дахь ялын хамгийн хүнд хэлбэр, хэмжээ болсон.

Хүн хулгайлах гэмт хэргийн хувьд хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхэлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж эрхшээлдээ оруулан авч явсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар, хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагаас ялгамжтай байх хуулийн зохицуулалт үйлчилж байна.

Шинээр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хүн хулгайлах үйлдлийг тодорхой болгон нэрлэж, хохирогчид хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхлэх зэргээр эрхшээлдээ оруулан авч явсан үйлдлийг хүн хулгайлах гэмт хэрэгт тооцож үндсэн бүрэлдэхүүнд оногдуулах хорих ялын доод хэмжээг тус хуулийн интервальд нийцүүлэн бууруулж, дээд хэмжээг 5 жил гэж хэвээр хадгалсан, хүндрүүлэх бүрэлдэхүүнд оногдуулах хорих ялын хэмжээг нэмэгдүүлж тогтоосон.

**ДӨРӨВ:** Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

1. Сургалт, судалгааны чиглэлээр:

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Монгол Улс дахь гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, хэтийн төлөв хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлох зорилгоор “Гэмт хэргийн цагаан ном” товхимлыг гаргасан бөгөөд уг номын 10 дугаар бүлэгт хүн худалдаалах гэмт явдлын талаарх судалгаа багтсан.

Уг судалгаанд хүн худалдаалах гэмт хэргийн шалтгааныг дараах байдлаар авч үзсэн байна.

- Нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал,
- Ажилгүйдэл, ядуурлын төвшин нэмэгдсэн,
- Иргэд гадаад улсад ажиллах, суралцах сонирхол нэмэгдэж, гадагшаа чиглэсэн хүн амын урсгал ихэссэн,
- Иргэдийн хялбар аргаар мөнгө олох хүсэл нэмэгдсэн зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн суурь шалтгаан болохыг дурджээ.

Үүнээс гадна гадаад оронд өндөр цалинтай ажилд зуучлах нэрээр хууран мэхэлж хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртүүлэх;  
-Хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлах;

- Охид, эмэгтэйчүүдийг хууран мэхэлж биеэ үнэлэхэд татан оролцуулах;
- Гэмт этгээдүүд биеэ үнэлэгчдийг гадаадад биеэ үнэлэхийг ятгаж, их хэмжээний мөнгө амлан, улмаар зөвшөөрүүлж улсын хил давуулах;
- Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь эргээд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч болох гэсэн хандлагуудыг тодорхойлсон байна.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн бөгөөд үнэлгээний тайланд хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрээр үйлдэгдэх хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлд анхаарал хандуулж, хөдөлмөрийн мөлжлөгийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах талаар зөвлөсөн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхийг үнэлэх” судалгааг хийж гүйцэтгэлээ.

Уг судалгаанд шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах болон гадаадын иргэн, харьяатын байгууллагын нийт 361 албан хаагч хамрагдсан бөгөөд асуулга хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тухайн албан хаагчийн мэдлэг, ойлголтыг тодорхойлсон.

Судалгааны дүнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг энэ төрлийн гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголтод хүргэх, илүү мэргэшүүлэн ажиллуулах, шаталсан сургалтуудад хамруулах хэрэгцээ шаардлага байгаа нь харагдсан.

Мөн уг судалгаанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 18-35 насны эмэгтэйчүүдийг хамруулснаас энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар асуусан асуултад дараах байдлаар хариулжээ.<sup>6</sup>

Д/Д	Нөлөөлж буй хүчин зүйл	Тоо	Хувь
1.	Гэр бүлийн таагүй орчин /эцэг эхийн таарамжгүй байдал, хойд эцэг эх, гэр бүл салалт, гэр оронгүй байдал/	14	70%
2.	Ажилгүйдэл	9	45%
3.	Нийгэмд үүсээд байгаа архидалт	6	30%
4.	Эдийн засгийн хүндрэл	8	40%
5.	Зар сурталчилгаа	3	15%
6.	Гэр бүлийн хүчирхийлэл	3	15%
7.	Найз нөхөд, орчны нөлөөлөл	6	30%
8.	Хувь хүний төлөвшил /бусдад хэт итгэх, хялбар аргаар мөнгө олох, зорилгогүй гадуур сэлгүүцэх	5	25%

Одоогийн байдлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн

<sup>6</sup> Эх сурвалж: Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан /2017 он/

судалгаа, хохирогчдын судалгаа, хөдөлмөрийн мөлжлөгийн талаар тандалт судалгааг мэргэжлийн байгууллагад захиалан гүйцэтгүүлж байна. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах, боловсруулах цахим сан бий болгох ажлыг зохион байгуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын гарын авлагыг тухайн байгууллагуудын саналыг тусган боловсруулж, хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр 40 сургагч багш бэлтгэн дээрх байгууллагуудын 300 албан хаагчийг сургасан.

Мөн Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдлэг олгох сургалтад Гадаад харилцааны яамны Консулын газрын 40 ажилтан, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх чиглэлээр хил хамгаалах, гадаадын иргэн харьяат, цагдаа, шүүх, прокурорын байгууллагын 128 албан хаагчийг тус тус сургалаа.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэргийн 29 хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлснээс гадна хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 20 сэтгүүлч, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх хууль зүйн тусламцааг сайжруулах зорилгоор 50 өмгөөлөгчийг мэргэшүүлэх сургалтад хамрууллаа. Мөн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл бүхий аж ахуйн нэгжүүдийн 40 ажилтанг урьдчилан сэргийлэх, хохирогчийг таних чиглэлээр сургалаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн хамгааллын салбарын оролцоо, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр 80 нийгмийн ажилтанг сургалтад хамрууллаа.

## 2. Хамтын ажиллагаа, сурталчилгааны чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн яам гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллагын дэргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зөвлөгөө өгөх төв, тусгай дугаарын утас ажиллуулж, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх дэлхийн өдөр “Хөх зүрхний аян”-ыг 2017, 2018 онд зохион байгуулж, эрсдэл бүхий аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1.150 хүүхдийг сургалтад хамруулж, цахим орчинд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт 62.400 хүнд хүргэсэн.



Хүн худалдаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг, мэдээллийн агуулгатай паспортын хавчуурга бэлтгэн 120.000 ширхэгийг хэвлүүлж хилээр нэвтэрч буй иргэдэд тогтмол тараах ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үзүүлж байна. “Сэргийлэгч” нэвтрүүлгийг 14 хоног тутамд 1 удаа олон нийтэд хүргэдэг бөгөөд 3 удаагийн дугаарыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газартай хамтран цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүний дотор хүн худалдаалах, хүн хулгайлах, бэлгийн мөлжлөг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “UNFRIEND” тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх агуулга бүхий 55 постер, 15 видео сурталчилгаа, нэвтрүүлэг, 1 дуу бүтээж 31 телевиз, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор 6.101.000 хүнд хүрсэн байна.

Тусгай арга хэмжээний үеэр олон нийтийн сүлжээн дэх садар самуун сурталчилсан болон хууль бус агуулга бүхий контент агуулсан групп, пэйж хуудсуудын мэдээллийг хүлээн авах “Хар жагсаалт” группыг үүсгэн 19,300 гишүүнийг элсүүлэн ажилласны зэрэгцээ хууль бус үйл ажиллагаа явуулсан 32 нийгмийн сүлжээний хуудас, группыг илрүүлж, Фэйсбүүк-д REPORT явуулж устгах арга хэмжээг авч ажиллав.

**ТАВ.** Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бусад салбаруудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хохирогч хамгааллын тогтолцоог сайжруулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар:

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох зорилгоор хамгаалах байр байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;

Хуульд заасан хохирогчдод үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох, зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх замаар гүйцэтгүүлж, хохирогчдыг эргэн нийгэмшүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах ажлыг эрчимжүүлэх;

Гадаад улсад хүн худалдаалах, хүн хулгайлах зэрэг гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эргүүлэн авчрах ажилд Иргэдэд туслах сангийн хөрөнгөөс дэмжлэг үзүүлэх, гадаад улс дахь Монгол Улсын Консулын газрын ажилтнуудыг чадавхжуулах;

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээг сайжруулахад эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх;

Хүүхдийг хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтнуудыг сургах;

Хүүхдийг хүн худалдаалах, хүн хулгайлах, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, өөр бусад эрсдэл, гэмт явдлаас өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрсэн тохиолдолд хандах байгууллагын талаар мэдлэг олгох сургалтын агуулгыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын насны онцлогт тохируулан иргэний боловсрол хичээлийн агуулгад тусгах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

--o0o--